



Нээдэлж 1993 оны #209 дэхүү ажлын  
БИМАУ түүшүүг.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГЛА

1988 ОНЫ 9  
сарын 30. өдөр

дугаар 255

Улаанбаатар хот—11  
улаас

Багануудын гахайн фермийн  
талаар авах зорилт ага  
хэмжээний тухай

БИМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1985 оны 308 дугаар тогтоо-  
лыг хөргүүлэх үндсэн дээр Багануудын районд баригдаж байгаа  
100 мэгжтэй гахайн фермийн барилгыг ашиглалтад хулээн авахтай  
холбогдуулан Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас  
ТОГООХ нь:

1. Багануудын районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны харьцанд  
100 мэгжтэй аж ахуйн тооцостой гахайн фермийг байгуулж районы  
одоо байгаа нэгдээ туслах аж ахуйн захиргааг тус фермтэй нэгт-  
гээ нэг удирдлагатай ажиллуулсугай.

2. Хотын төлөвлөгөөний комисс /и.Батбаяр/, Барилга захи-  
лагчийн товчоо /и.Гомбосурэн/, Кедее аж ахуйг удирдах газар  
/и.Мижиддорж/-т ДААЛГАХ нь:

a/ Багануудын районы гахайн фермийн барилгын ажлын явц  
удаашралтай, хулээн авах бэлтгэл хангагдаагүй сайдлыг харгал-  
зан тус фермд баригдаж байгаа 7,2 сая төгрөгийн тесевт өргөтгэй  
36 объектос 4136,0 мянган төгрөгийн тесевт өргөтгэй 28 барилга  
объектийг 1988 оны II дүгээр сарын 25-нд ашиглалтад оруулах, ул-  
дэх 3064,0 мянган төгрөгийн тесевт өргөтгэй 8 барилгыг 1989 оны  
эхний хагаст багтали тус тус ашиглалтад өгөхөөр 1988 оны төлөв-  
лөгөөнд захицуулж хийсугэй.

б. Гахайн фермийн барилгад ийлүүлэгдээгүй байгаа ОСМ-60  
маркийн төрон хайс 4 ком, гахайн ПРН-1 маркийн услуудууд,  
ИК-УФ-ІМ маркийн дүүжин гарлууд "Климат-47" маркийн салхивчийн  
санс 70 ширхэг, "ТСМ-160" маркийн транспортер 2 ком, мөн цемент  
200 тн, 3/2 см-ийн банс 90 м3, 5 см-ийн банс 60 м3-ийг тус тус

10 дугаар сард багтаан нийлүүлэх арга хэмжээ авсугай.

в. Гахайн фермийн үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор өрөмцмэл худаг нэгийг 1989 онд нэмж гаргах, ажиллагсдын нийгэм ахуйн үйлчилгээнд зориулан 12 айлын орон сууи, соёл-ахуйн үйлчилгээ, цайны газрын барилгын зураг төсвийг 1989 оны эхний хагаст багтаан гаргуулж, барих ажлыг 1990 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсугай.

3. Гахайн фермийн барилгын эхний эзлж /хавсралт № I-/ийг энэ оны II дүгээр сарын 25-нд, хоёрдугаар эзлж /хавсралт № 2/-ийг 1989 оны эхний хагаст багтаан тус тус дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөхийг ТТҮБ трест /н.Шагнарагчай/, Цахилгаан сантехник угсралтын нэгдсэн трест /н.Дамрин/-д уг ажлын явцад техникийн хяналт тавьж, чанартай гүйцэтгүүлэхийг барилга захиалгчийн товчоо /н.Гомбостран/, Хөдөө аж ахуйг удирдах газар /н.Мижилдорж/-д даалгасугай.

4. Багануурин районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.Дашдаваа/-д ДААЛГАХ нь:

а/ Багануурин районы 100 мэргжтай гахайн фермд ашиглалтын ёмнөх захиргааг дарга, зоотехнич-технологич, малых эмч, нягтлан бодогч-эдийн засагч, еренхий механикч, аж ахуй-тэжээлийн нярав зэрэг үндсэн 6 орон тоотойгоор энэ оны 10 дугаар сарын I-нээс эхлэн байгуулж, шаардагдах гахайчин, техникийн ажилчлыг авч ажиллуулсугай.

б/ Гахайн фермийн барилгын эхний эзлжийг энэ оны II дүгээр сард ашиглалтад хулаэн авах, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг хангахтай холбогдуулан мэжж, бодон авах, тэжээл, нуурс татах зэрэг бусад бэлтгэлийг 1988 оны 12 дугаар сарын I-ний дотор хангах арга хэмжээ авсугай.

в/ Районы нэгдсэн туслаж ахуйд одоо байгаа гахайг бордож таргалуулан борлуулж, уг овложоор гахайн шинэ фермийн уржлийн сураг салбах гахай худалдан авсугай.

5. Гахайн фермийн үйлдвэрлэлийг эхлэн явуулахад заильшгүй шаардлагатай мэжж 100, бодон 15 МТЗ-80 дугуйт трактор, чиглүүлийн хамт З, орон сууц ахуйн үйлчилгээний зориулалтаар гэр 10-ыг хөрөнгө оруулалтаар энэ оны II дүгээр сард багтаан авч хангах арга хэмжээ авсугай.

## 3.

гахыг Хотын төлөвлөгөөний комисс /н.Батбаяр/-т даалгасугай.

6. Багануувын районы гахайн фермийн захиргааны орон тоо, цалингийн фонд, эргэлтийн хөрөнгийн нормативыг шинэчлэн тогтоох, 1988 онд шаардагдах эргэлтийн хөрөнгө 150,0 мянган төгрөгийг хотын төсвийн орлогын төлөвлөгөө давуулсан шатналын хөрөнгөнөөс гаргахыг хотын санхүүгийн хэлтэс /н.Гонгор/-т даалгасугай.

7."Гахайн фермийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг цаашид бүрэн эзэмшихэд зайлшгүй шаардагдах мэргэжлийн боловсон хүчин, автомашин, хөдөө аж ахуйн техник, зарим тоног төхөөрөмжийг 1989 оноос эхлэн жил жилийн төлөвлөгөө, захиалгад тусган олгох арга хэмжээ авахыг Хотын төлөвлөгөөний комисс /н.Батбаяр/, Хөдөө аж ахуйг удирдах газар /н.Мижиддорж/-т уурэг болгосугай.

8. Багануувын районы гахайн фермийн үйлдвэрлэлийн технологийн зөвлөмж боловсруулах, фермийн хүч чадлыг дүүрэн ашиглахад нь туслах мэргэжлийн группийг энэ оны 10 дүгээр саад томилон ажиллуулж, цаашид байнгын удирдлагаар хангаж ажилдахыг Улаанбаатар хотын Гахайн завод /н.Басанжав /-т уурэг болгосугай.

9. Энэ тогтоолын биелдлэд хяналт тавьж ажилдахыг Хөдөө аж ахуйг удирдах газар /н.Мижиддорж/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЭЦУУТАТУУДЫН  
ХҮРЛҮН ГҮЙЦЭГТЭХ ЗАХИРТЫНЫ  
ДАРГА *Д.МОНХЖАРГАЛ*

УЛААНБААТАР ХОТЫН АДХЫН ГҮЙЦЭГТЭХ  
ЗАХИРТЫНЫ ХАРИУЦЛАГАТЫН НАРИИН  
БЧТИЙН ДАРГА *отп* *Д.АЛГИА*